



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/21


Улаанбаатар хот

Цахилгааны инженерийн орон тоо
батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Нийслэлийн засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын бүтэц, орон тоог батлах тухай А/1047 тоот захирамж, газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн Дулааны инженерийн орон тоог Цахилгааны инженер болгон өөрчилсүгэй.
2. Байгууллагын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Цахилгааны инженерийн ажлын байрны шинжилгээг хийхийг Хүний нөөцийн мэргэжилтэн /Э.Энгүүн/-д, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахыг Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хэлтсийн дарга /Н.Пүрэвсүрэн/, Хүний нөөцийн мэргэжилтэн /Э.Энгүүн/ нарт үүрэг болгосугай.
3. Цахилгааны инженерийн нээлттэй ажлын байр зарлахыг Хүний нөөцийн мэргэжилтэн /Э.Энгүүн/-д даалгасугай.

ДАРГА



С БАТЖАРГАЛ